



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/210.

Улаанбаатар хот

Байгууллагын стратеги төлөвлөгөө
боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Захиргаа, удирдлагын газрын дарга

Гишүүд:

Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн зохицуулалт, шалгалт тохируулгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмж, ложистикийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Эмийн чанар, аюулгүй байдлын тандалт судалгааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Шинэ эм, эмнэлзүйн судалгааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Чанарын хяналтын газрын ахлах, Эм, биобэлдмэлийн хяналтын улсын ахлах байцаагч

Эмийн бүртгэлийн зохицуулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

1422 01210

Эм үйлдвэрлэлийн асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн

Эм шинжлэх лабораторийн чанарын ахлах
мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Маркетинг, төлөвлөгөө, тайлан хариуцсан
мэргэжилтэн

2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын стратеги төлөвлөгөөг 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн дотор боловсруулж, Даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

3. Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/102 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА